



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дуут сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2024/006/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2025 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Н.Батжаргал

Утас: 99432788

Цахим хаяг: batjargaln@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
(мянган төгрөг).....	9
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ДУУТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.БАТСҮХ ТАНАА

2025.03.21 № 2/193
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ховд аймгийн Дуут сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 60 дугаар зүйлийн 60.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.3, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.2.2 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ОНХС-аар хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ажлууд нь батлагдсан зураг төсөө, техник эдийн засгийн үндэслэлгүй Засаг даргаар батлуулсан ажлын даалгавраар хийгдсэн,
- ОНХС-аар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудад захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй, захиалагчийн хяналтын зардал баталж суутган тооцоогүй,
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Залуучуудын хөгжлийн хөтөлбөр арга хэмжээний хүрээнд Засаг даргын захирамжаар урсгал үйл ажиллагааны зардал ОНХС-аас 56,096.2 мянган төгрөг зарцуулсан,

- ОНХС-аас 14,547.7 мянган төгрөгийн гадаад туршлага судлах аялал зохион байгуулсан,
- Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтүүд хуваарийн дагуу хийгдээгүй 15,941.0 мянган төгрөг,
- Малжуулах төсөлд олгосон зээлийн авлага барагдуулаагүй 8,147.0 мянган төгрөгийн зөрчлүүд илэрсэн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Дуут сум нь 2024 оны татварын болон татварын бус орлого өмнөх оноос 215.8 сая төгрөгөөр нэмэгдэж, нийт 457.3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь 16.2 сая төгрөг буюу 3.7 хувиар төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Дуут сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны тайланд зарим нэр төрлийн татварын орлогууд тухайлбал малын тоо толгойн албан татвар, байгалийн нөөц ашигласны төлбөр, газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө биелээгүй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/мян.төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	405,418.12	517,921.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	136,649.80	247,156.70
33	АВЛАГА	222,151.01	191,092.80
34	УРЬДЧИЛГАА	9,147.70	46,647.70
35	БАРАА МАТЕРИАЛ	37,469.60	33,024.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,897,809.80	2,035,982.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,897,809.80	2,035,982.00
39200	Биет хөрөнгө	1,765,439.80	1,903,612.00
39300	Биет бус хөрөнгө	132,370.00	132,370.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,303,227.92	2,553,903.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	41,947.97	4,274.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	41,947.97	4,274.80
41300	Өглөг	41,947.97	4,274.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,261,280.00	2,549,628.90
51	Засгийн газрын хувь оролцоо	2,261,280.00	2,549,628.90
51100	Засгийн газрын оруулсан капитал	876,858.10	876,858.10
51200	Хуримтлагдсан үр дүн	1,141,464.30	1,429,813.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	242,957.50	242,957.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,303,227.92	2,553,903.80

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,797,803.2	2,151,204.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	238,584.3	455,462.9
110	Орлогын албан татвар	152,300.2	337,063.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	164,330.7	350,439.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-12,030.5	-13,375.2
113	Хөрөнгийн албан татвар	36,565.8	70,163.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	49,718.3	48,235.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	474,583.2	238,446.9
120	Нийтлэг татварын бус орлого	474,583.2	238,446.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,084,635.7	1,457,294.1

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,405,846.3	1,871,241.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,405,846.3	1,871,241.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,347,652.6	1,832,197.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,354.4	679,305.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,095.8	85,907.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,241.7	364,621.9
2104	Хангамж, бараа материалын зардал	308,961.2	346,912.4
2105	Нормативт зардал	326.0	945.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,787.7	12,911.1
2107	Томилолт, зочны зардал	5,852.0	7,808.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400,814.0	168,755.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,219.9	165,029.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,058,193.7	39,043.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	391,956.9	279,962.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	391,956.9	279,962.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,390,919.7	1,949,908.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	246,970.7	455,462.9
110	Орлогын албан татвар	152,300.2	337,063.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	164,330.7	350,439.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-12,030.5	-13,375.2
113	Хөрөнгийн албан татвар	36,565.8	70,163.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	58,104.7	48,235.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,918.2	10,468.1
1181	Газрын төлбөр	11,852.8	4,523.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	34,333.6	33,244.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	55,528.1	37,151.6
120	Нийтлэг татварын бус орлого	55,528.1	37,151.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,088,420.9	1,457,294.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,012,118.1	1,388,782.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,012,118.1	1,388,782.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	953,924.3	1,349,738.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	418,187.6	677,518.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,262.6	85,787.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,241.7	470,184.1
2104	Хангамж, бараа материалын зардал	18,727.9	24,648.4
2105	Нормативт зардал	502.4	546.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,867.6	11,204.0
2107	Томилолт, зочны зардал	5,852.0	7,808.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	390,341.9	33,727.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,940.7	38,313.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,058,193.7	39,043.5

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	378,801.6	561,126.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	260,325.7	450,469.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	260,325.7	450,469.7
2200	Дотоод эх үүсвэрээр	260,325.7	450,469.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-260,325.7	-450,469.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-126,100.0	-150.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	126,100.0	150.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-7,624.1	110,506.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	144,273.9	136,649.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	136,649.8	247,156.7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,858.1	242,957.5	750,987.5	1,870,803.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,480.0)	(1,480.0)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,858.1	242,957.5	749,507.5	1,869,323.1
9	Тайлант үеийн үр дүн	-	-	391,956.9	391,956.9
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,858.1	242,957.5	1,141,464.3	2,261,280.0
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	876,858.1	242,957.5	1,141,464.3	2,261,280.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	8,386.4	8,386.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,858.1	242,957.5	1,149,850.7	2,269,666.3
19	Тайлант үеийн үр дүн	-	-	279,962.6	279,962.6
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	876,858.1	242,957.5	1,429,813.3	2,549,628.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,997,922.30	1,832,945.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,435,211.60	1,382,325.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,396,168.10	1,343,282.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	704,241.10	677,518.53
210101	Үндсэн цалин	361,983.20	361,899.08
210102	Нэмэгдэл	280,435.80	264,301.66
210104	Урамшуулал	38,062.10	30,877.39
210105	Гэрээт ажлын хөлс	23,760.00	20,440.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,037.10	85,787.10
210201	Тэтгэврийн даатгал	59,865.00	58,335.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,043.00	6,852.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,842.70	3,709.20
210204	Ажилгүйдлийн даатгал	3,200.50	3,164.50
210205	Эрүүл мэндийн даатгал	14,085.90	13,725.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	493,929.10	470,184.14
210301	Гэрэл, цахилгаан	26,562.40	23,854.76
210302	Түлш, халаалт	462,402.60	446,208.38
210303	Цэвэр, бохир ус	4,964.10	121.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,945.70	23,921.23
210401	Бичиг хэрэг	3,332.00	3,307.60
210402	Тээвэр, шатахуун	16,739.90	16,739.83
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,873.80	3,873.80
2105	Нормативд зардал	553.70	546.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	553.70	546.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,204.00	11,204.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317.00	317.00
210604	Урсгал засвар	10,887.00	10,887.00
2107	Томилолт, зочны зардал	7,886.00	7,808.70
210702	Дотоод албан томилолт	7,886.00	7,808.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,211.00	32,184.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,998.00	29,972.00
210803	Даатгалын үйлчилгээ	346.00	345.98
210804	Тээврийн хэрэгслийн татвар	285.00	284.93
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	34.00	34.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,240.50	1,240.50
210807	Газрын төлбөр	307.50	306.72
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,160.40	34,127.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,363.60	31,330.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,796.80	2,796.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,043.50	39,043.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,043.50	39,043.50
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,302.00	37,302.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,741.50	1,741.50

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	562,560.70	450,469.70
220001	Барилга байгууламж	152,098.60	152,098.60
221001	Их засвар	125,800.00	117,467.21
222001	Тоног төхөөрөмж	123,679.60	71,425.20
223001	Бусад хөрөнгө	160,982.50	109,478.69
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150.00	150.00
230001	Эргэж төлөгдөх зээл	150.00	150.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,997,922.30	1,889,440.45
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,886,990.80	1,853,508.82
320001	Орон нутгийн төсвөөс	1,559,661.00	1,526,179.02
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	327,329.80	327,329.80
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	110,931.50	35,931.64
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605.00	605.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150.00	35,326.64
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	56,138.15
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	112,633.09

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	2023 оны дүн	2024 оны дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,718.30	10,811.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,718.30	10,811.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,331.90	6,456.3
2104	Хангамж, бараа материалын зардал		727.2
210402	Тээвэр, шатахуун		727.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,331.90	1,543.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,331.90	1,543.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		4,186.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4,186.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,386.40	4,354.8
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,386.40	4,354.8
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	8,386.40	4,354.8
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,718.30	10,811.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,718.30	10,811.1

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,743.70	5,876.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,318.10	843.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,656.50	4,091.9

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 133,231.9 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илэрснээс аудитын явцад 38,500.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Хогийн цэг булшлах хашаажуулах ажлын санхүүжилтийн 70 хувь 35,000.0 мянган төгрөгийг урьдчилж олгосон боловч урьдчилж гарсан зардлаар бүртгээгүйг залруулсан.
- Шивэр багийн зам засварын ажлын санхүүжилтийн 70 хувь 3,500.0 мянган төгрөгийг урьдчилж олгосон боловч урьдчилж гарсан зардлаар бүртгээгүйг залруулсан.

Залруулагдаагүй зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул **"Хязгаарлалттай"** дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчилд² 14,547.7 мянган төгрөгийн албан шаардлага өгч, 80,184.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: БНХАУ-ын ӨМӨЗО-ны Урумчи хотын сумдын ажил байдалтай танилцах туршлага судлах аялал зохион байгуулж, Засаг даргын захирамжаар зардлын мөнгийг Оюу хайрхан уул ХХК-руу шилжүүлсэн, анхан шатны баримт, зарцуулалтын тайлангүй, үргүй зардал гаргасан 14,547.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 60 дугаар зүйлийн 60.3.6-д "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

3.2 Зөвлөмж

3.2.1 Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтүүд хуваарийн дагуу хийгдээгүй 15,941.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 10 дугаар зүйлийн 10.1-д "Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийг төлүүлэн ажиллах, төлөөгүй үлдэгдэлд алданги тооцож Монгол банкны зээлийн мэдээллийн санд мэдээлэх.*

3.2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлттэй холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: 2024 оны ОНХС-аар хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ажлууд нь батлагдсан зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй, Засаг даргаар батлуулсан ажлын даалгавраар хийгдсэн зөрчил нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.3.3 "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль, ОНХС-ын журмыг мөрдөн ажиллах, зураг төсөвгүй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх.

3.2.3. Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Батлагдсан зураг төсөвгүйгээр ажлын даалгавраар хийгдэж байгаа ажлуудад захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй, захиалагчийн хяналтын зардал баталж суутган тооцоогүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.4.3-д "Бүх өр төлбөрийг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ" Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.2.2-т "Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ОНХС-ын журмыг мөрдөн ажиллах, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

3.2.4. Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-ын хөрөнгө оруулалтаар данс бүртгэлд тусгах боломжгүй төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөн санхүүжүүлсэн. Тухайлбал: Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Залуучуудын хөгжлийн хөтөлбөр арга хэмжээний хүрээнд Засаг даргын захирамжаар урсгал үйл ажиллагааны зардал санхүүжүүлсэн байна. Үүнд: Замын зардал, шатахуун, багш нарын баяр, барилдааны шагнал, тэмцээний шагнал, хүүхдийн баяр зэрэг 56,096.2 мянган төгрөг зарцуулсан зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", "60.4.Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт тухайн засаг захиргааны нэгжийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3 "үр ашигтай байх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ОНХС-ын журмыг мөрдөж ажиллах, урсгал үйл ажиллагааны шинжтэй удирдлагыг хэрэгжүүлэх зардал санхүүжүүлэхгүй байх.

3.2.5. Малжуулах зээлийн сангийн авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Малжуулах төсөлд 2015 онд олгосон зээлийн үлдэгдэл 8,147.0 мянган төгрөгийн авлага барагдуулаагүй зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагыг барагдуулан ажиллах байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 07 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Дуут сумын ТТЗ	Хогийн цэг булшлах хашаажуулах ажлын санхүүжилтийн 70 хувь 35,000.0 мянган төгрөгийг урьдчилж олгосон боловч урьдчилж гарсан зардлаар бүртгээгүйг залруулсан.	1	35,000.0			1	35,000.0	1	35,000.0				
	Шивэр багийн зам засварын ажлын санхүүжилтийн 70 хувь 3,500.0 мянган төгрөгийг урьдчилж олгосон боловч урьдчилж гарсан зардлаар бүртгээгүйг залруулсан.	1	3,500.0			1	3,500.0	1	3,500.0				
ДҮН		2	38,500.0			2	38,500.0	2	38,500.0				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Дуут сумын ТТЗ	Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтүүд хуваарийн дагуу хийгдээгүй байна	1	15,941.0					1	15,941.0		
	2024 оны ОНХС-аар хийгдсэн ажлууд нь батлагдсан зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй, ажлын даалгавраар хийгдсэн байна.	1	0					1	0		
	Захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй, захиалагчийн хяналтын зардал баталж суутган тооцоогүй.	1	0					1	0		
	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Залуучуудын хөгжлийн хөтөлбөр арга	1	56,096.2					1	56,096.2		

